

“Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Архигүй Дундговь” арга хэмжээний тайлан

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ард иргэдээ архидалтгүй эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг” ТББ-тай хамтран аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга Б.Түвшинбаяр, Аймгийн цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Розон нараар ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 10 сарын 05-ны өдөр Дэлгэрцогт суманд сургалт сурталчилгаа, мэдээллийн өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр МУСГЗ, Зохиолч яруу найрагч Ж.Цогтсугар сумын удирдлагуудтай болон иргэд, цэргийн насны залуучуудтай уулзалт хийж, “Тархины нууц” илтгэлийг тавьсан юм. Тэрээр илтгэлийнхээ эхэнд танхим дүүрэн цугласан хүмүүст хандан “Өнөөдрийн миний тархины лекцэнд тархиндаа мэдлэг хийхээр хүрэлцэн ирсэн хамгийн оюунлаг иргэд та бүхэнд баяр хүргэе!” хэмээн онцоллоо. Мөн “Монголын эрэгтэйчүүдийн нийгэмлэг” ТББ-н гишүүн О.Батсайхан 9-н жилийн сургуулийн 6-9-р ангийн сурагчдын дунд сургалт, илтгэлийг зохион байгууллаа. Мөн энэхүү өдөрлөгийн хүрээнд МУСГЗ Ж.Цогтсугар болон сумын Засаг даргын орлогчтой хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсанаар цаашид “Архидалтгүй аймаг – Дундговь –ийг бүтээхийн тулд гурван чиглэлээр байнгын хамтын ажиллагаа хийх боломжийг бүрдүүлж байгаа юм.

